



ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА



ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

"МОНГОЛ ДАХЬ ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙ ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ

Сайн бодлого сайхан амьдралын эхлэл

2017 он



ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ЯВАГДАЖ БАЙЖ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БИЙ БОЛЖ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭРХ АШИГ ХАНГАГДАНА.



ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага)-ийн
Монгол дахь төлөөлөгчийн газар
Улаанбаатар хот Сүхбаатарын талбай-3 Бодь цамхаг 7 давхар
TEL: +976-11-325939, 312393 FAX: +976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

Төслийн ажлын байр
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг Самбуугийн гудамж-11 Засгийн газрын байх XI 1009 тоот

"МОНГОЛ ДАХЬ ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙ ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ

ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2015 ОНЫ 9 ДҮГЭЭР САР - 2018 ОНЫ 8 ДУГААР САР

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын зах зээлд аж ахуйн нэгжүүд шударга бөгөөд чөлөөтэйгээр өрсөлдөх орчинг сайжруулж, улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Өрсөлдөөний хууль хэрэгжүүлэгч байгууллагын болон байцаагч, албан хаагчдын чадавхи, өрсөлдөөний бодлого, эрх зүйн орчныг сайжруулах, хууль сахиулах байгууллага, төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн зах зээлийн өрсөлдөөний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ

"Шударга Өрсөлдөөний Орчныг Бэхжүүлэх нь" төслийг Монгол Улсын ядуурлыг бууруулах үндэсний стратегийн хүрээнд зах зээл дэх өрсөлдөөний орчныг сайжруулах, өрсөлдөөний хууль эрх зүйн актуудыг шинэчлэх зорилготойгоор 2015 оны 9 дүгээр сараас Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг ШӨХТГ-тай хамтран хэрэгжүүлэх гэрээ байгуулсан.

Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргадаг "Дэлхий дахины өрсөлдөх чадварын индекс"-ийн тайланд тухайн эдийн засгийн бүтээмжийн түвшинг тодорхойлох институци¹, бодлого, хүчин зүйлийн цогцыг өрсөлдөх чавдар гэж тодорхойлсон байдаг байна. Энэ тодорхойлолтоос дүгнэхэд улс орны өрсөлдөх чадвар нэмэгдэнэ гэдэг нь тухайн орны бүтээмжийн түвшин өснө, бүтээмжийн өсөлт нь эргээд үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хурдасгана. Улмаар иргэдийн орлого нэмэгдэж, ажил эрхлэлт өсч, ядуурал буурах нөхцөл бүрдэх аж.

Дээрх уламжлалт ойлголтоос гадна 2007 оноос хойших дэлхийн эдийн засгийн хандлага нь "өрсөлдөх чадвар тухайн эдийн засгийн тэсвэрлэх чадварыг сайжруулдаг" гэсэн таамаглалыг баталж байна. 2008 оны эдийн засгийн хямралаас өмнө өрсөлдөөн сайтай гэсэн ангилалд багтаж байсан орнууд хямралыг амжилттай тэсч гарсан төдийгүй эргэн хурдан сэргэж чадсан байна. Түүнчлэн өрсөлдөөн сайтай эдийн засгууд ажилгүйдлийнхээ түвшинг хямралын өмнөх түвшин хүртэл буулгаж чадсан бол өрсөлдөөн багатай орнуудын хувьд ажилгүйдлийн түвшин хямралын өмнөх түвшнээс дээгүүр тогтож үлджээ.

1 Институци гэдэг нь хүмүүсийн үйл хөдлөлийг хязгаарлаж, түүнийг хөшүүрэгдэж байдаг албан болон албан бус хууль, дүрэм, журам юм. Мөн үүнд хууль болон албан ёсны хязгаарлалтуудаас гадна ёс заншил, бичигдээгүй хууль, албан бус харилцаа, шашин шүтлэг, тогтсон арга барил зэрэг хувь хүмүүсийн үйл хөдлөлийг ямар нэг байдлаар хязгаарлаж, тодорхойлж байдаг хязгаарлалтууд орно.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ НЬ “ӨРСӨЛДӨӨН” ЮМ.

Хөгжиж буй орнуудад тохиолддог нийтлэг асуудлуудын нэг нь засгийн газрын зохисгүй, тогтворгүй бодлого, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанаас хамааралтай олон төрлийн өрсөлдөөний саад байдаг. Эдгээр нь инновацийн дэвшил болон зах зээлийн өсөлтийг хязгаарладаг бөгөөд эцсийн дүнд хэрэглэгчид хохирдог байна.

Мөн Монгол, Япон хоёр улсын хооронд байгуулсан Эдийн Засгийн Түншлэлийн Хэлэлцээрт Монгол Улс нь өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд хориг тавьж, хоёр орны хооронд хийх худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал нь саадгүй явагдах тал дээр арга хэмжээ авч ажиллана гэж заасан ба ЭЗТХэлэлцээрт тусгасан Хэрэгжүүлэх хэлэлцээрээр Монгол, Япон Улсын засгийн газрууд нь өрсөлдөөний хууль бодлогыг хэрэгжүүлэхэд хоёр орны өрсөлдөөний байгууллагуудын хооронд техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж хамтран ажиллах нь чухал гэдэгт санал нэгдсэн байна.

ШӨХТГ нь 2014 оны байдлаар, бичгээр 1495, утсаар 912, Засгийн газрын “11-11” төвөөр дамжуулан өрсөлдөөний хуулийн хэрэгжилттэй холбоотой 159 өргөдөл гомдол тус тус хүлээн авч, 2115 хуулийн этгээд бүхий 1146 хэргийг шийдвэрлэж 333,294,456.00 төгрөгийн торгууль ноогдуулж, 1,140,145,000.00 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. Эдийн засгийн өсөлтийг дагаж зах зээл тэлэхийн хэрээр ялгавартай үнэ тогтоох, давамгайл байдлаа буруугаар ашиглах зэрэг шударга бус худалдааны аргууд илэрч байгаа ба үүнтэй зэрэгцээд ШӨХТГ-ын улсын байцаагч нарыг өрсөлдөөний тухай хуулийн зөрчлийн талаархи ерөнхий ойлголт, зах зээлд дүн шинжилгээ хийх аргачлал, өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэх тайлбарлах аргачлал зэрэгт сургах шаардлага тулгарч байна.



АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ХУДАЛДААГАА ӨРГӨЖҮҮЛЖ, АШИГ ОРЛОГОО НЭМЭХИЙН ТӨЛӨӨХ ӨРСӨЛДӨӨН НЬ ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨДӨЛГӨХ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛДОГ

ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮН:

1. Өрсөлдөөний бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох


2. ШӨХТГ-ын байцаагч, албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх

3. Зах зээлийн судалгааны арга аргачлал, хяналт шалгалтын гарын авлага гэх мэт баримт бичгийг сайжруулах

4. Өрсөлдөөний бодлого, хуулийн талаар олон нийтэд таниулан сурталчилах



ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ





ШӨХТГ-ын төлөөлөл:

- Дарга – Төслийн Удирдагч
- Өрсөлдөөн хариуцсан орон тооны гишүүн
- Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга
- Өрсөлдөөний бодлого зохицуулалтын газрын дарга
- Зах зээл судалгааны газрын дарга
- Хамтын ажиллагааны газрын дарга
- Төрийн захиргаа, удирдлагын газрын төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
- Өрсөлдөөний бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
- Хамтын ажиллагааны газрын гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн
 - Сангийн яамны төлөөлөгч

ШӨХТГ

- Өрсөлдөөн хариуцсан орон тооны гишүүн
- Холбогдох албан хаагчид (Ажлын хэсэг)

Хамтарсан
Удирдах
Хороо

Төслийн
хэрэгжүүлэх
нэгж

ЖАЙКА-ийн Монгол дахь
төлөөлөгчийн газар

Япон Улсын ЭСЯ /
ажиглагч/

ЖАЙКА төслийн гишүүн

Бусад шаардлагатай
төлөөлөл

ЖАЙКА-ийн мэргэжилтэн
- Төслийн баг

ЯПОНЫ ШУДАРГА ХУДАЛДААНЫ ХОРОО (ЯШХХ)-НЫ ТУХАЙ

Япон Улсад дэлхийн хоёрдугаар дайны дараагаар эдийн засгийн хөгжлийг дэмжиж, зах зээл дээр чөлөөтэй, шударга өрсөлдөөнийг бий болгох зорилготойгоор 1947 онд Зүй бус монополийн эсрэг хуулийг батлан гаргасан бөгөөд тус хуулийн хэрэгжилтийг ханган ажилладаг Японы Шударга Худалдааны Хороо /ЯШХХ/ нь 1949 онд үүсгэн байгуулагдсан байна.

ЯШХХ нь өдгөө 830 гаруй ажилтан албан хаагчидтай, үйл ажиллагаагаараа Азид төдийгүй дэлхийд томоохонд тооцогдох өрсөлдөөний байгууллага болон өргөжсөн байна.

Тусхороонь Зүй бус монополийг хориглох, шударга худалдааг баримтлах тухай хууль, Туслан гүйцэтгэхийн тухай хууль, Шударга бус худалдаанаас сэргийлэх тухай хууль зэрэг хуулиудын хэрэгжилтийг хангаж ажилладаг.

2015 оноос ЖАЙКА Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй Монгол Улсын шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд мэргэжлийн арга зүй, зөвлөгөө өгөхөөс гадна дотоод болон гадаад сургалтуудыг ЖАЙКА, ШӨХТГ-тэй хамтран зохион байгуулдаг.

Өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлж ирсэн 70 орчим жилийн баялаг туршлагаасаа заан сургаж, Монгол Улсын өрсөлдөөний хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

ШУДАРГА БӨГӨӨД ЧӨЛӨӨТ ӨРСӨЛДӨӨН АЖ АХУЙН НЭГЖИЙГ Ч ХЭРЭГЛЭГЧДИЙГ Ч ХАМГААЛЖ БАЙДАГ

Аж ахуйн нэгжүүд өөрсдийн нийлүүлж буй бараа, үйлчилгээг олноор борлуулж ашгаа өсгөхийн тулд худалдан авагч талын хүсэл сонирхолд нийцүүлэх гэж өдөр тутамдаа хичээж, ижил төрлийн бараа, үйлчилгээ үзүүлж байдаг бусад аж ахуйн нэгжүүдтэйгээ өрсөлдөж байдаг. Зөвхөн хямд үнэтэй төдийгүй, чанартай, үйлчилгээ сайтай, баталгаат хугацаатай гэх мэтээр янз бүрээр ур ухаанаа уралдуулж шинийг сэдэж өрсөлдөхийг шударга өрсөлдөөн гэнэ.

ШУДАРГА ӨРСӨЛДСӨНИЙ ҮР ДҮНД



Гэтэл зарим аж ахуйн нэгж өөрсдийн ашгийг хамгаалах зорилгоор зах зээлийн давамгайл байдлаа зүй бусаар ашиглах, картель хийх зэргээр зах зээлийн жам ёсны өрсөлдөөнийг хязгаарлах, гажуудуулах явдал цөөнгүй байдаг.

Өрсөлдөөний хуулиар зах зээлийн шударга бөгөөд чөлөөт өрсөлдөөнийг баталгаажуулж, өрсөлдөөний соёлыг төлөвшүүлж, улмаар улс орны эдийн засгийн эрүүл хөгжлийг хамгаалж байдаг.





ЯМАР ТОХИОЛДОЛД ӨРСӨЛДӨӨНГҮЙ БОЛОХ ВЭ?

ЗАХ ЗЭЭЛИЙН МОНОПОЛЬ БАЙДАЛТАЙ ҮЕД


Зах зээлийн эдийн засгийн “монополь” гэдэг ойлголт нь нэг зах зээл дээр цорын ганц нийлүүлэгч компани оршин тогтнохыг хэлдэг. Зах зээл дээрх ганц тоглогч болох монополь компани өрсөлдөгчгүй тул үнээ бууруулах, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, илүү шинийг сэдэж, бүтээхэд хойрго ханддаг байна. Хүмүүс манайхаас худалдаж авахаас өөр аргагүй болохоор үнээ нэмчихье, бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг сайжруулахад зардал ихтэй ч юм иймээрээ байхад болноо гэх мэт сэтгэлээр хандаж эхэлдэг байна.

Эцсийн бүлэгт чанаргүй бүтээгдэхүүнийг, өндөр үнээр худалдаж авах нөхцөл байдал үүсч хэрэглэгчид хохирч эхэлдэг.



КАРТЕЛЬ ХИЙХ ҮЕД

Нэг зах зээл дээр олон өрсөлдөгч байсан ч өрсөлдөөнгүй болох тохиолдол байдаг. Энэ нь картель юм. Өөрөөр хэлбэл, нэг зах зээл дээрх компаниуд тохиролцож өрсөлдөөнөө зогсоохыг картель гэнэ.



Ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг компаниуд хоорондоо үнэ, тоо хэмжээ, худалдаалах газар нутгийг тохиролцдог.

Картель, тендерийн хуйвалдаан гэх мэт өрсөлдөөнийг үгүй болгодог үйл ажиллагааг өрсөлдөөнд харш үйл ажиллагаа гэж хэлж болох юм. Хэдийгээр өрсөлдөөнийг үгүй болгохгүй ч гэсэн өрсөлдөөнийг хязгаарладаг үйл ажиллагааг мөн өрсөлдөөний хуулиар хянан зохицуулдаг.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ЯМАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРСӨЛДӨӨНИЙГ ХЯЗГААРЛАСАН ГЭЖ ҮЗЭХ ВЭ?



Ажахуйн нэгж өөрсдийн зүтгэл, хөдөлмөрийнхөө хүчээр зах зээлийн ихэнх хувийг эзэлдэг байх буюу давамгайл байх нь хууль зөрчсөн үйлдэл биш харин ч өрсөлдөөний ялагч гэдэг утгаараа сайшаах ёстой.

Харин давамгайл байдлаа буруугаар ашигласан үйл ажиллагаа явуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэхийг хүссэн тохиолдолд үүнийг өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа гэж үзэж хуулийн дагуу арга хэмжээ авдаг.

Ерөнхийдөө шударга бус худалдааны аргуудыг өрсөлдөөнийг хязгаарлах аюултай гэж үздэг:

ХЯЗГААРЛАЛТАЙ НӨХЦӨЛТЭЙГЭЭР ХУДАЛДАА ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- “Шахан зайлуулах /бусад аж ахуйн нэгжтэй худалдаа хийхгүй байх/ нөхцөл тогтоох”
- “Дахин борлуулах үнэ /жижиглэнгийн үнэ гэх мэт/-ийг тогтоох” зэрэг

ХҮЧЭЭР ХУДАЛДАА ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД


- “Хууран мэхлэх замаар харилцагчийг татах”
- “Үндэслэлгүй ашигтай нөхцөл санал болгож харилцагчийг татах”
- “Бараа дагалдуулан борлуулах” гэх мэт

ҮНДЭСЛЭЛГҮЙ ҮНЭ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- “Харилцагчдад ялгавартай үнэ тогтоох”
- “Өртгөөс доогуур үнээр худалдаалах”
- “Үндэслэлгүй өндөр үнээр худалдан авах” гэх мэт

БИЗНЕСТ СААД УЧРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- “Өрсөлдөгчийн бизнест саад учруулах”
- “Өрсөлдөгч компанийн дотоод хэрэгт оролцох” гэх мэт





ХУДАЛДАА ХИЙХЭЭС ТАТГАЛЗАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- "Хэд хэдэн компани хамтран татгалзах"
- "Худалдааны нөхцөлийг ялгавартай тогтоох"
- "Мэргэжлийн холбоо, байгууллагын ялгавартай хандлага" гэх мэт үйл ажиллагаанууд багтдаг.

Дээрх үйл ажиллагаануудаас гадна өрсөлдөөнийг хязгаарлах шинжтэй аж ахуйн нэгжийн нэгдлийн асуудлыг өрсөлдөөний байгууллага хянан зохицуулах шаардлагатай байдаг.

ААН-ИЙН НЭГДЭЛ

Орчин үеийн өрсөлдөөний эрх зүйгээр зохицуулагдаж буй харилцааны нэг чухал сэдэв нь ААН-ийн нэгдэл, зах зээлийн төвлөрлийн асуудал юм. ААН-ийн нэгдэл нь картель, тендерийн хуйвалдаан, зах зээлийг хуваах, давамгайл байдлаа буруугаар ашиглах зэрэг өрсөлдөөний эсрэг шууд чиглэсэн ажиллагаа биш боловч нэгдлийн үр дүнд нэг эсхүл хоёр компани зах зээлд өөрийн байр сууриа улам бэхжүүлж, улмаар өрсөлдөөнийг хязгаарлах байдал үүсэх сөрөг үр дагавартай байдаг.

Зах зээлд өрсөлдөгч ААН-үүд нийлж нэг ААН болох нь өрсөлдөөнийг их хэмжээгээр бууруулах эрсдэлтэй. Гэхдээ бүх төрлийн нэгдэл өрсөлдөөнийг үгүйсгэнэ гэж үзэх нь өрөөсгөл бөгөөд энэ асуудлыг тухайн улсын өрсөлдөөн хариуцсан байгууллагын хяналт шалгалтаар тогтооно.

Хяналт шалгалтаар ААН нэгдсэнээр өрсөлдөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг авч үзэхээс гадна тухайн нэгдлийг зөвшөөрснөөр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийг мөн тооцож үздэг. Энэ нь харьцангуй түвэгтэй тооцоолол шаардах хэдий ч тусгайлсан аргачлал, зааварчилгааг хэм хэмжээ болгон ашиглана.



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

ҮР ДҮН 1-ИЙН ХҮРЭЭНД ДАРААХ СУДАЛГААНУУДЫГ ХИЙГЭЭД БАЙНА

1. ШӨХТГ-ын хяналт шалгалтын ажлын дүн шинжилгээ П.Цэцгээ, В.Удвал

Өрсөлдөөний хууль эрх зүйн актууд болон бусад холбогдох материалыг эх сурвалж болгож ашигласны дээр судалгааны багийн гишүүдээс ШӨХТГ-ын улсын байцаагч болон мэргэжилтэн нарын 6 албан тушаалтан, ШӨХТГ-ийн захиргааны актад хамаарал бүхий иргэний төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Үүний үндсэн дээр ШӨХТГ-ын улсын байцаагчдын хяналт шалгалтын ажлууд (3 кейс) нь холбогдох хууль журмын хүрээнд, зарчмын дагуу, зүй зохистойгоор явагдсан эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. Хяналт шалгалтын үеийн процессийн алдаа гаргахгүй байх, Улсын байцаагчдын мэргэжлийн ур чадварыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гаргасан.

Доорх 5 судалгааг 2016 оны 7 сараас 11 сар хүртэл 4 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

2. Монгол улсын зах зээлийн өрсөлдөөн, өрсөлдөөний хууль эрх зүйн талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт болон зах зээлийн өнөөгийн төлөв байдал, нэвтрэх саадын судалгаа- Судалгааны баг Мирим ХХК

Судалгаа дараах 2 үндсэн зорилготой байсан

1. Зах зээлийн шударга өрсөлдөөн, өрсөлдөөний хууль эрх зүйн орчны талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт, мэдлэг, хандлага ямар байгааг түүвэр судалгааны аргаар тодорхойлж, дүн шинжилгээ хийх
2. МУ-ын голлох эдийн засгийн салбаруудад харгалзах зах зээлүүдийн өрсөлдөөний төлөв байдал болон зах зээлд нэвтрэх саадыг тодорхойлж, өрсөлдөөнийг дэмжих санал зөвлөмж боловсруулах

Судалгааны үр дүнгээс танилцуулбал:

- 2 %** Зах зээлийн хэлбэрийг зөв тодорхойлсон
- 82.5%** зах зээлийнхээ өрсөлдөөний түвшинг дунд болон дундаас дээш үнэлсэн
- 53.5%** төрийн байгууллага өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаа явуулж байна гэж үзсэн
- 61.2%** ШӨХТГ үйл ажиллагааг дунд болон дундаас дээш үнэлсэн
- 77.4%** Өрсөлдөөний тухай хуулийн үр өгөөжийг дунд болон дундаас дээш



Нэвтрэх саад ихтэй салбар

1. Цахилгаан эрчим хүч
2. Газрын тосны бүтээгдэхүүн
3. Металл хүдэр олборлолт
4. Банкны үйл ажиллагаа
5. Эмнэлэгийн үйл ажиллагаа

Шударга бус өрсөлдөөн ихтэй салбар

1. Цахилгаан эрчим хүч
2. Газрын тосны бүтээгдэхүүн
3. Барилга угсралт
4. Эмнэлэгийн үйл ажиллагаа
5. Банкны үйл ажиллагаа



3. Өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох суурь судалгаа – Судалгааны багийн ахлагч К. Жархынбек

Тус судалгааны хүрээнд,

Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн "Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа"

Тус хуулийн 13 дугаар зүйлийн "Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох"

- Дээрх зүйлүүдийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах явцад гарч буй бэрхшээл, алдаа, хуулийн хийдэл, зөрчилдөөнийг илрүүлж, тодорхойлсон
- Олон улсын загвар хууль болон гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлаж, нэмэлт өөрчлөлт оруулах санал зөвлөмж өгсөн
- Бусад холбогдох эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тогтоох, хуулийн төсөл боловсруулж санал болгосон



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

4. Давамгай байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох суурь судалгаа- Судалгааны багийн ахлагч Б.Шинэбаяр

- Өрсөлдөөний хуулийн 6, 7 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд ШӨХТГ-ын улсын байцаагч нарын гүйцэтгэсэн хяналт шалгалт, судалгааны ажлын хуулийн хэрэглээг судалж зөрчил илрүүлсэн байдал, гаргасан дүгнэлт, хийсэн судалгаа шинжилгээ, тооцоо оновчтой эсэхэд дүгнэлт өгсөн
- Дээрх зүйлийн заалтуудыг олон улсын загвар хуультай харьцуулан шинжилж, хууль хэрэглээг оновчтой болгох талаар санал зөвлөмж өгсөн
- Зүй ёсны монополийн үнэ, хэт өндөр ба бага үнэ, үнийн ялгаварлал, босоо хэлбэрийн дангаар ноёрхол, давамгай байдлаа буруугаар ашиглахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой эдийн засгийн дүн шинжилгээний арга аргачлал боловсруулсан
- Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийг хүчин чадалтай нь уялдуулан хянахтай холбоотой арга аргачлал боловсруулсан
- Зохицуулах байгууллагатай салбар дахь зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг хянаж зохицуулах, монополийг задлах асуудлаар бодлогын зөвлөмж боловсруулсан
- Дангаар ноёрхох, түүний босоо хэлбэрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн үндэслэл, аргачлалыг боловсруулсан
- Давамгай байдлаа хууль бусаар ашигласан үйл ажиллагааг илрүүлэхэд чиглэсэн хяналт зохицуулалтын гарын авлага боловсруулсан
- Засгийн газрын 298 дугаар тогтоолоор батлагдсан "Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулсан
- Шаардлагатай гарын авлага боловсруулах ажлын хүрээнд доорх 4 гарын авлагыг боловсруулсан
 1. Давамгай байдал, босоо хэлбэрийн үйл ажиллагаа, үнийн ялгаварлал тогтоохтой холбоотой арга аргачлал
 2. Давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох зах зээлийн судалгаа, шинжилгээний гарын авлага
 3. Хэт өндөр үнийг хянан зохицуулах гарын авлага
 4. Хэт бага үнийг хянан зохицуулах гарын авлага



5. Нэгдэн нийлэх үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох суурь судалгаа – Судалгааны багийн ахлагч Б. Батсүх

- Аж ахуйн нэгж, компаниуд нь бусдыгаа худалдан авах, өөртөө нэгтгэх үйл явцыг хянан зохицуулах талаар гадаадын зарим орны туршлагыг судлаж, өөрийн улсад тулгарч буй асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг санал болгосон

- Аж ахуйн нэгжийн нэгдэлтэй

холбоотой зүйл заалтын шинэчилсэн хувилбарыг санал болгосон

- Засгийн газрын 118 дугаар тогтоолоор батлагдсан "Давамгайл байдалтай хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах журам"-д нэмэлт өөрчлөх оруулах санал боловсруулсан
- Нэгдэн нийлэх хяналт тавих процессыг хэрэгжүүлэх гарын авлага боловсруулсан

6. Өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ, хэлцэл, картелийн хяналт зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох суурь судалгаа – Судалгааны багийн ахлагч Ж. Очирхуяг

- Зах зээлд өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцэл хийх, үгсэн хуйвалдах /картель/ үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх, нотлох хянаж шийдвэрлэхтэй холбогдсон хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал өгсөн
- Өрсөлдөөний хуулийн картельтай холбоотой зүйл заалтын шинэчилсэн хувилбарыг санал болгосон
- Бусад холбогдох эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тогтоох, хуулийн төсөл боловсруулж санал болгосон
- Картелийн нийгэм, эдийн засагт үзүүлэх хор нөлөөллийг тодорхойлох арга, аргачлал боловсруулсан



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН СУРГАЛТ, СЕМИНАР, ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД



МОНГОЛД:

№	Сургалт хэлэлцүүлэгийн сэдэв	Огноо	
Дотоодод зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг			
1	<p>“Өрсөлдөөний хууль ба бодлогын хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэг</p> <p>Дэд сэдэвүүд:</p> <ul style="list-style-type: none"> Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журмын хэрэгжилт, ололт ба дутагдал Давамгай байдалтай хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах журмын хэрэгжилт, ололт ба дутагдал Одоо мөрдөгдөж буй Өрсөлдөөний тухай хуулийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй хүндрэл 	2015 оны 11 дүгээр сарын 25-27-ны өдрүүд	
2	<p>“Өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилт, өөрчлөлт хийх шаардлага” сэдэвт хэлэлцүүлэг</p> <p>Дэд сэдвүүд :</p> <ul style="list-style-type: none"> ЯШХХ-ны хяналт шалгалтын процесс Хяналт шалгалтын үйл ажиллагааны дүн шинжилгээнд суурилсан сургалтын төлөвлөгөөний төсөл хэлэлцэх Өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд Шударга худалдааны хорооны олон нийттэй харьцах үйл ажиллагаа Өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэглээ Өрсөлдөөний эрх зүйн орчинг боловсронгуй болгох тухай санал, зөвлөмж Өрсөлдөөний тухай хуулинд өөрчлөлт оруулах тухай санал, зөвлөмж 	2016 оны 1 дүгээр сарын 27-28-ны өдрүүд	
3	Жайка төслийн Судалгааны зөвлөх багуудын явцын тайлангийн хэлэлцүүлэг	2016 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүд	
4	“Өрсөлдөөний хуулийн өөрчлөлтийн ерөнхий чиглэл” дотоод сургалт	2016 оны 11-р сарын 16-ны өдөр	
5	“Өрсөлдөөний хуулийн өөрчлөлтийн ерөнхий чиглэл” хэлэлцүүлэг	2017 оны 11-р сарын 17-ны өдөр	
Дүн			



	Байршил	зорилго	Зорилтот бүлэг	Оролцогчдын тоо			Нийт
				ШӨХТГ	Бусад	ЯЦХХ ЖАЙКА	
	Улаанбаатар хот Бишрэлт зочид буудал	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын /ШӨХТГ/ хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үр дүнтэй, зөв зохистой хэрэгждэг болгох	Төрийн болон Төрийн бус байгууллагууд, шүүгч, судлаач, зүй ёсны монополь болон давамгайл байдлтай аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл	7	90	3	100
	Улаанбаатар хот "Blue Sky Tower"	Өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж хуулинд өөрчлөлт оруулах талаар оролцогчдоос санал, зөвлөмж авах	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан хаагчид болон Хууль зүйн яамны холбогдох мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, шүүгчид	37	57	6	100
	Улаанбаатар хот Улаанбаатар зочид буудал	5 Зөвлөх багийн судалгааны ажлын явцын тайланг хэлэлцэх	ШӨХТГ-ын улсын байцаагчид болон Жайка төслийн Судалгааны Зөвлөх багийн гишүүд	19	12	6	37
	Улаанбаатар хот Corporate зочид буудал	Монгол улсын Өрсөлдөөний тухай хуулийг боловсронгуй болгох ерөнхий чиглэлийг тодорхойлж олон нийтээр хэлэлцүүлэх	ШӨХТГ-ын болон орон нутгийн улсын байцаагч нарт зориулсан ШӨХТГ-ын улсын байцаагч нарт зориулсан	53 63	90	7 7	60 160
			Давхардсан тоогоор	179	249	29	457

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН СУРГАЛТ, СЕМИНАР, ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД



Индонези дахь сургалтын үеэр (2016.9)

	Сэдэв	Огноо	Байршил
1	«Өрсөлдөөний хууль ба бодлого» сэдэвт	2016 оны 1 дүгээр сарын 10-16-ны өдрүүдэд	Япон улсын Токио хотод
2	ШӨХТГ-ын удирдлага, улсын байцаагч нар болон ШЕЗ-ийн Шүүгч нарт зориулсан сургалт	2016 оны 5 дугаар сарын 22-29-ны өдрүүдэд	Япон улсын Токио хотод
3	Индонез улсын Бизнесийн өрсөлдөөнийг хянан зохицуулах хороо (KPPU)-ны туршлагатай танилцах сургалт	2016 оны 9 дүгээр сарын 12-17-ны өдрүүдэд	Индонез улсын Жакарта болон Сурабая хотод
	Дүн		



Япон дахь сургалтад оролцогчид ЖАЙКА-ийн төв оффисын төлөөлөлтэй хамт (2016.5)



Индонези дахь сургалтад оролцогчид (2016.9)



Япон дахь сургалтын үеэр (2016.5)



Сургалтад оролцсон шүүгч нар (2016.5)

Зорилго	Зорилтот бүлэг	Оролцогчдын тоо		Нийт
		ШӨХТГ	Бусад	
Олон улсын Өрсөлдөөний хууль ба бодлогын асуудал, онол арга зүй	ШӨХТГ-ын улсын байцаагч нар болон МУ-ын Шадар сайдын ажлын албаны төлөөлөл	8	6	14
Олон улсын Өрсөлдөөний хууль ба бодлогын асуудал, онол арга зүй	ШӨХТГ-ын удирдлага, улсын байцаагч нар болон ШЕЗ-ийн Шүүгч нар	7	10	17
Индонез улсын Бизнесийн өрсөлдөөнийг хянан зохицуулах хорооны туршлагатай танилцах	ШӨХТГ-ын удирдлага, улсын байцаагч нар болон УИХ-ын нишүүн ШСА-ын төлөөлөл	7	5	12
	Давхардсан тоогоор	22	21	43




Япон дахь сургалтын үеэр ЯШХХ-ны даргатай уулзаж талархалаа илэрхийлэв



Индонези улсын Бизнесийн өрсөлдөөнийг хянан зохицуулах хороо (KPPU)-ны даргатай уулзаж туршлага солилцов



Индонезийн Парламентын гишүүдтэй уулзаж өрсөлдөөний бодлого, хуулийн талаар санал солилцов



ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага)-ийн
Монгол дахь төлөөлөгчийн газар
Улаанбаатар хот Сүхбаатарын талбай-3 Бодь цамхаг 7 давхар
TEL: +976-11-325939, 312393 FAX: +976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

Төслийн ажлын байр
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Самбуугийн гудамж-11 Засгийн
газрын байх XI 1009 тоот